



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/219

Улаанбаатар хот

**Чингэлтэй дүүргийн Цагдаагийн
хоёрдугаар хэлтсийн данснаас
барилга хасах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 68 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/486 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2017 оны 02-07-388/111 дүгээр актын дагуу Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах, энэ тушаалын хавсралтад заасан 1,028,160.0 /нэг сая хорин найман мянга нэг зуун жаран/ төгрөгийн үнэ бүхий барилгыг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хоёрдугаар хэлтэс /Ц.Сугаржав/-т зөвшөөрсүгэй.

2. Данс бүртгэлээс хасагдаж буй барилгыг буулгах ажлыг зохион байгуулах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хоёрдугаар хэлтэс /Ц.Сугаржав/-т, хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах боломжтой материалыг хөндлөнгийн үнэлгээний байгууллагын үнэлсэн 58,000.0 /Тавин найман мянган/ төгрөгөөр худалдан борлуулж, орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх, акт болон бусад баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т тус тус даалгасугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны .07 дугаар сарын
05 өдрийн 8/21 дугаар тушаалын хавсралт



АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ
БАРИЛГЫН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Бүртгэлийн үнэ /2019.03.31/	Хуримтлагдсан элэгдэл /2019.03.31/	Үлдэгдэл өртөг /2019.03.31/	Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн акт
1	Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн Жигжид зуслан дахь хэсгийн байр	2001	Чингэлтэй дүүрэг, 19-р хороо, Жигжид гудамж	1,028,160	1,028,160	0	2017.10.24-ны өдрийн 02-07-177/111 тоот акт
НИЙТ ДҮН				1,028,160	1,028,160	0	